

8.4.1. Суралцагч нэмэх

Суралцагч нэмэх үйлдэл хийхээс өмнө дараах нөхцөл биелсэн байх шаардлагатай. **Үүнд:**

- Улсын иргэний бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн байх
- Гадаад суралцагч бол оршин суух үнэмлэхийн мэдээлэл ДБУСМ-ийн санд бүртгэгдсэн байх
- Элсүүлж авах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө үүссэн бөгөөд төлөв нь идэвхтэй байх
- Суралцагч элсэлтийн ерөнхий шаардлагыг хангасан байх


Суралцагч нэмэх үйлдлээр тухайн хичээлийн жилд шинээр элссэн, гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагаас шилжиж ирсэн суралцагчийг бүртгэнэ.

Суралцагч шинээр бүртгэх үйлдлийг дараах дарааллаар хийнэ. **Үүнд:**


1. **Суралцагч** ерөнхий цэсийг сонгоно.
2. Суралцагчийн дэд хэсгээс **жагсаалтийг** сонгоно.
3. Цонхны баруун дээд хэсэгт байрлах **Суралцагч нэмэх** товчийг дарна.
4. Суралцагчаар авах хүн **хайж** сонгоно.
5. Суралцагч нэмэх цонхны мэдээллийг оруулаад **хадгалах** товч дарна.
6. Хэрэв баталгаажуулах хүсэлт илгээх бол баталгаажуулах хүсэлт гэсний урд чеклээд хадгалах товч дарна. Ингэхэд систем автоматаар шалгаж шинээр бүртгэсэн суралцагч шалгуур хангасан эсэхийг мэдээлнэ.

Сургалтын хөтөлбөр бүртгэх үйлдлийн дэлгэрэнгүй тайлбар:

1. **Суралцагч** ерөнхий цэсийг сонгоно.




2. Суралцагчийн дэд хэсгээс **жагсаалт**ийг сонгоно.



The screenshot shows the DBUMS application interface. The top navigation bar has a tab labeled "Жагсаалт" (List) which is highlighted with a red box. Below the navigation bar, the main content area displays a table of survey results. The table has columns for #, Регистр, Эцэг/эхийн нэр, Нэр, Хөтөлбөр, Хөтөлбөрийн код, Суралцагчийн түвшин, Төлөв, Харьяаллын хаяг, Оршин суугаа хаяг, and Хү.

#	Регистр	Эцэг/эхийн нэр	Нэр	Хөтөлбөр	Хөтөлбөрийн код	Суралцагчийн түвшин	Төлөв	Харъяаллын хаяг	Оршин суугаа хаяг	Хү
1	ух85082003	Мөнхжаргал	Мөнхцэцэг	Санхүү	041201	1-р дамжаа	Суралцаж байгаа	Улаанбаатар, Баянзүр	Улаанбаатар, Чингэлт	Эм
2	ф687081213	Баянмөнх	Наранбат	Санхүү	041201	2-р дамжаа	Суралцаж байгаа			Эр
3	ед80041363	Даваацэрэн	Мөнхзаяа	Газрын тосны инженер - Гадаад	072404 - Гадаад	1-р дамжаа	Суралцаж байгаа			Эм
4	ны03321618	Батбаатар	Батсүрэн	Газрын тосны инженер - Гадаад	072404 - Гадаад	1-р дамжаа	Суралцаж байгаа	Төв, Лүн, 2-р баг, Өгөө		Эр

3. Цонхны баруун дээд хэсэгт байрлах **Суралцагч нэмэх** товчийг дарна.



The screenshot shows the DBUMS application interface. The top navigation bar has a tab labeled "Жагсаалт" (List). In the top right corner of the main content area, there is a button labeled "Суралцагч нэмэх" (Add Surveyor) which is highlighted with a red box. Below the navigation bar, the main content area displays a table of survey results, similar to the one in the previous screenshot.

#	Регистр	Эцэг/эхийн нэр	Нэр	Хөтөлбөр	Хөтөлбөрийн код	Суралцагчийн түвшин	Төлөв	Харъяаллын хаяг	Оршин суугаа хаяг	Хү
1	ух85082003	Мөнхжаргал	Мөнхцэцэг	Санхүү	041201	1-р дамжаа	Суралцаж байгаа	Улаанбаатар, Баянзүр	Улаанбаатар, Чингэлт	Эм
2	ф687081213	Баянмөнх	Наранбат	Санхүү	041201	2-р дамжаа	Суралцаж байгаа			Эр
3	ед80041363	Даваацэрэн	Мөнхзаяа	Газрын тосны инженер - Гадаад	072404 - Гадаад	1-р дамжаа	Суралцаж байгаа			Эм
4	ны03321618	Батбаатар	Батсүрэн	Газрын тосны инженер - Гадаад	072404 - Гадаад	1-р дамжаа	Суралцаж байгаа	Төв, Лүн, 2-р баг, Өгөө		Эр

4. Суралцагчаар авах хүн **хайж** сонгоно.

Суралцагч нэмэх үед монгол хүн бол иргэний бүртгэл мэдээллийн сангаас шалгаж хүний мэдээллийг татаж авах бөгөөд регистрийн дугаар зөв байх шаардлагатай. Хэрэв гадаад хүн бол оршин суух үнэмлэх, гадаад паспортын хуулбар, форматын дагуу бүртгэсэн мэдээллийн хамт системийн админд өгч системийн гадаад хүний санд нэмүүлэх шаардлагатай. Ингэж нэмүүлсний дараа системд гадаад суралцагчийг сонгож, бүртгэх боломжтой болно.

- Дараах тохиолдлуудад **Баталгаажуулах хүсэлт илгээх** сонголтыг хийн БСШУСЯ-ны мэргэжилтэн рүү баталгаажуулах хүсэлт илгээнэ. Үүнд:

- Гадаадын бүрэн дунд, техник, мэргэжлийн боловсролоос элсэгч
- 2006 ба түүнээс өмнөх онд бүрэн дунд боловсрол эзэмшигчээс элссэн суралцагч
- Шашны сургуульд суралцагч

БСШУСЯ-ны мэргэжилтэн уг хүсэлтийг шалган батлагдаагүй төлөвт буй суралцагчийг баталгаажуулах эсвэл цуцлах үйлдэл хийнэ.

Суралцагч бүртгэх мэдээллийн тайлбар

Хувийн мэдээлэл

Суралцагч нэмэх үед монгол хүн бол иргэний бүртгэл мэдээллийн сангаас шалгаж хүний үндсэн мэдээллийг татаж авах бөгөөд регистрийн дугаараар оруулна. Хэрэв гадаад хүн бол улс, хүйс, төрсөн огноо, гадаад паспортын дугаар оруулснаар бүртгэх боломжтой болно.

No. 1.	Талбар Ургийн овог	Тайлбар Монгол хүний хувьд регистр, гадаад хүний хувьд харъяалагдах улс, хүйс, төрсөн огноо, гадаад паспортын дугаар оруулсанаар уг мэдээлэл автоматаар бөглөгдөнө.	Жишээ Сартуул
2.	Эцэг/Эхийн нэр	Монгол хүний хувьд регистр, гадаад хүний хувьд харъяалагдах улс, хүйс, төрсөн огноо, гадаад паспортын дугаар оруулсанаар уг мэдээлэл автоматаар бөглөгдөнө.	Бат
3.	Нэр	Монгол хүний хувьд регистр, гадаад хүний хувьд харъяалагдах улс, хүйс, төрсөн огноо, гадаад паспортын дугаар оруулсанаар уг мэдээлэл автоматаар бөглөгдөнө.	Дорж
4.	Төрсөн огноо	Монгол хүний хувьд регистр, гадаад хүний хувьд харъяалагдах улс, хүйс, төрсөн огноо, гадаад паспортын дугаар оруулсанаар уг мэдээлэл автоматаар бөглөгдөнө.	2000.01.01
5.	Хүйс	Монгол хүний хувьд регистр, гадаад хүний хувьд харъяалагдах улс, хүйс, төрсөн огноо,	Эр

No.	Талбар	Тайлбар гадаад паспортын дугаар оруулсанаар уг мэдээлэл автоматаар бөглөгдөнө.	Жишээ
-----	--------	--	-------

Сургалтын мэдээлэл

Суралцагчийн сургалтын хөтөлбөр, сургалтын ерөнхий мэдээллийг харуулна.

No. 1.	Талбар Оюутны код	Тайлбар Суралцагчийн дугаар автомат гэсэн талбарын ард байрлах тэмдэглэгээг болиулах үед суралцагчийн дугаарыг гараас бичих талбар идэвхжинэ. Эсвэл автомат дугаарлалт хийх боломжтой.	Жишээ sw03d001
2.	Сургууль	Суралцагчийн элссэн, шилжиж ирсэн бүрэлдэхүүн, салбар сургуулийг сонгоно.	Бизнесийн сургууль
3.	Боловсролын түвшин	Суралцагчийн элсэн орж буй боловсролын түвшинг сонгоно.	Бакалаврын боловсрол
4.	Мэргэжлийн чиглэл	Тухайн хөтөлбөрийн харьяалагдах мэргэжлийн чиглэл сонгоно. Мэргэжлийн чиглэл нь тусгай зөвшөөрөлд бүртгэгдсэн нөхцөл шаардлагаас сонгогдоно.	Бизнесийн удирдлага
5.	Сургалтын хөтөлбөр	Суралцагчийн элссэн, шилжиж ирсэн сургалтын хөтөлбөрийг сонгоно.	Бизнесийн удирдлага
6.	Төлөвлөгөө	Сургалтын төлөвлөгөөг сонгоно. Энд зөвхөн дээр сонгосон сургалтын хөтөлбөрт харьяалуулж бүртгэсэн төлөвлөгөөний жагсаалт харагдана.	2018 оны төлөвлөгөө
7.	Суралцагчийн түвшин	Үе шаттай хөтөлбөрийн хувьд суралцагчийн түвшинг сонгох талбар идэвхтэй байна. Тохирох суралцагчийн түвшинг сонгоно.	1-р дамжаа
8.	Сургалтын хэлбэр		